**ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК**

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

# Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХӨА-2026/041/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Мөрөн сум<br>2026 он | Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг:tegshdelgerb@audit.gov.mn<br>Аудитор: Б.Ариунтуяа<br>Утас: 99036832 Цахим хаяг: ariuntuyab@audit.gov.mn<br>Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа<br>Утас:99389208 Цахим хаяг: b_myadagmaaa@yahoo.com<br>Аудитор Ц.Мөнхтуяа<br>Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 01/163
танай ______________-ны № ______________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ө.ОТГОНГЭРЭЛ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Улаан-Уул сумын Эрүүл мэндийн төв нь тайланд онд Эрүүл мэндийн даатгалын сангаас 6,861.7 мянган төгрөгийн санхүүжилтийн авлагатай гарсан байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Аудитаар нийт 70,158.5 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс, 53,550.9 мянган төгрөгийн 8 алдааг залруулж, 16,607.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

#### Бусад асуудлын хэсэг

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас Улаан-Уул сумын Эрүүл мэндийн төвтэй байгуулсан анхан шатны тусламж үйлчилгээг худалдан авах 2025 оны гэрээний биелэлтийг 78.5 хувьтай дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А. ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **256,383,169.44** | **194,182,262.31** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4,746,665.22 | 63,515,499.55 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 4,746,665.22 | 63,515,499.55 |
| **3121** | **Төгрөг** | 4,746,665.22 | 63,515,499.55 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,746,665.22 | 63,515,499.55 |
| **33** | **АВЛАГА** | 123,972,848.21 | 7,023,989.39 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 162,222.49 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 123,972,848.21 | 6,861,766.90 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 2,312,026.00 | 3,585,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 2,312,026.00 | 3,585,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 125,351,630.01 | 120,057,773.37 |
| **351** | **Түүхий эд материал** | 44,750,653.76 | 36,101,279.53 |
| 35130 | Эм боох материал | 44,750,653.76 | 36,101,279.53 |
| **354** | **Хангамжийн материал** | 80,600,976.25 | 83,956,493.84 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 238,100.00 | 1,873,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 63,228,006.17 | 58,385,837.77 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 3,340,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,333,880.08 | 5,821,392.07 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 1,220,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 2,066,390.00 | 581,164.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12,734,600.00 | 12,734,600.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **847,399,049.43** | **776,249,364.69** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 847,399,049.43 | 776,249,364.69 |
| **392** | **Биет хөрөнгө** | 807,201,049.43 | 736,051,364.69 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 373,606,381.42 | 373,606,381.42 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -68,163,673.95 | -73,400,417.07 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 282,452,681.00 | 288,452,681.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -124,434,171.13 | -170,018,569.58 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 573,225,280.15 | 619,990,280.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -254,162,663.58 | -320,121,530.30 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,784,733.53 | 40,784,733.53 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -26,687,936.72 | -33,249,814.11 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,070,540.00 | 17,070,540.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -6,735,121.29 | -7,307,920.35 |
| 39217 | Ном | 245,000.00 | 245,000.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 40,198,000.00 | 40,198,000.00 |
| 39301 | Програм хангамж | 15,400,000.00 | 15,400,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -400,000.00 | -400,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,198,000.00 | 25,198,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,103,782,218.87** | **970,431,627.00** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **9,408,160.00** | **941,030.85** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 9,408,160.00 | 941,030.85 |
| **413** | **Өглөг** | 9,408,160.00 | 941,030.85 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 4,934,460.00 | 941,030.85 |
| **4136** | **Бусад өглөг** | 4,473,700.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 4,473,700.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,094,374,058.87** | **969,490,596.15** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,094,374,058.87 | 969,490,596.15 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 366,022,288.00 | 366,022,288.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 51101 | Өмч:  - төрийн | 366,022,288.00 | 366,022,288.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 612,763,014.00 | 487,879,551.28 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 612,763,014.00 | 612,763,014.00 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -124,883,462.72 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 115,588,756.87 | 115,588,756.87 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI** | **1,103,782,218.87** | **970,431,627.00** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,665,627,425.55** | **1,605,996,801.12** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **334,118,766.09** | **178,072,403.12** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 334,118,766.09 | 178,072,403.12 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 334,118,766.09 | 178,072,403.12 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,112,000.00 | 121,634,093.80 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-үндсэн хөрөнгө | 269,676,879.40 | 36,755,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-бараа материал | 33,329,886.69 | 19,683,309.32 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,331,508,659.46** | **1,427,924,398.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,594,800.00 | 44,817,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,594,800.00 | 44,817,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,292,913,859.46 | 1,383,106,898.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,292,913,859.46 | 1,383,106,898.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,434,002,915.20** | **1,726,433,463.89** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,434,002,915.20** | **1,726,433,463.89** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,404,351,536.46 | 1,621,905,694.89 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 889,696,766.15 | 1,047,144,584.90 |
| 210101 | Үндсэн цалин | 470,710,935.88 | 533,930,767.66 |
| 210102 | Нэмэгдэл | 295,413,963.79 | 374,359,190.84 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,052,000.00 | 34,955,000.00 |
| 210104 | Урамшуулал | 103,519,866.48 | 103,899,626.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,331,600.00 | 131,863,441.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,239,500.00 | 89,377,541.39 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,908,500.00 | 10,424,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,600,000.00 | 5,606,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,600,000.00 | 5,606,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,983,600.00 | 20,848,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,021,541.23 | 40,208,018.84 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,055,421.26 | 9,020,530.85 |
| 210302 | Түлш, халаалт | 25,966,119.97 | 31,162,487.99 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 25,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 85,559,411.07 | 92,571,937.42 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,478,170.00 | 18,959,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,575,715.97 | 44,616,200.02 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,015,700.00 | 2,976,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 11,064,500.00 | 2,982,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,114,680.00 | 12,546,720.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 13,310,645.10 | 10,491,117.40 |
| **2105** | **Нормативт зардал** | 133,703,830.24 | 147,632,447.55 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 107,437,829.24 | 125,041,785.55 |
| 210502 | Хоол, хүнс | 26,266,001.00 | 22,590,662.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,500,800.00 | 21,810,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 11,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,500,800.00 | 9,910,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,831,600.00 | 8,129,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,831,600.00 | 8,129,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,413,310.00 | 5,322,480.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,487,000.00 | 3,084,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 289,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 249,716.00 | 621,986.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 75,594.00 | 75,594.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 142,292,677.77 | 127,222,884.79 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,698,600.00 | 00.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 124,594,077.77 | 127,222,884.79 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 29,651,378.74 | 104,527,769.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,112,000.00 | 104,527,769.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 53,179,769.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,112,000.00 | 51,348,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 539,378.74 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 539,378.74 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **231,624,510.35** | **-120,436,662.77** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 4,446,799.95 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 4,446,799.95 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | 00.00 | -4,446,799.95 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **231,624,510.35** | **-124,883,462.72** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,281,414,834.25** | **1,666,669,573.11** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **31,112,000.00** | **121,634,093.80** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 31,112,000.00 | 121,634,093.80 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 31,112,000.00 | 121,634,093.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 31,112,000.00 | 121,634,093.80 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,250,302,834.25** | **1,545,035,479.31** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 38,594,800.00 | 44,817,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 38,594,800.00 | 44,817,500.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,211,708,034.25 | 1,500,217,979.31 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 1,211,708,034.25 | 1,500,217,979.31 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,275,249,540.15** | **1,584,135,738.78** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,275,249,540.15** | **1,584,135,738.78** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,245,598,161.41** | **1,479,607,969.78** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 889,696,766.15 | 1,047,144,584.90 |
| 210101 | Үндсэн цалин | 470,710,935.88 | 533,930,767.66 |
| 210102 | Нэмэгдэл | 295,413,963.79 | 374,359,190.84 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 20,052,000.00 | 34,955,000.00 |
| 210104 | Урамшуулал | 103,519,866.48 | 103,899,626.40 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 101,331,600.00 | 132,025,663.88 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,239,500.00 | 89,539,763.88 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,908,500.00 | 10,424,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,600,000.00 | 5,606,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,600,000.00 | 5,606,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,983,600.00 | 20,848,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 35,055,421.26 | 42,754,500.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,055,421.26 | 8,079,500.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,000,000.00 | 34,650,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 25,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 64,524,112.00 | 72,933,974.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,299,320.00 | 8,490,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 46,645,592.00 | 45,889,174.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,015,700.00 | 2,976,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,925,000.00 | 4,148,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 8,638,500.00 | 11,429,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 125,763,552.00 | 125,518,467.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 96,319,100.00 | 103,596,531.00 |
| 210502 | Хоол, хүнс | 26,644,452.00 | 19,961,936.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,800,000.00 | 1,960,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,561,300.00 | 26,059,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 17,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 11,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,561,300.00 | 14,142,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 4,831,600.00 | 8,129,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 4,831,600.00 | 8,129,600.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,413,310.00 | 7,142,480.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,487,000.00 | 4,824,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152,000.00 | 1,152,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 289,900.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 249,716.00 | 621,986.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 99,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 75,594.00 | 75,594.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 00.00 | 80,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,420,500.00 | 17,899,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,420,500.00 | 17,899,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **29,651,378.74** | **104,527,769.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 29,112,000.00 | 104,527,769.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 53,179,769.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 29,112,000.00 | 51,348,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 539,378.74 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 539,378.74 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **6,165,294.10** | **82,533,834.33** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **00.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **2,150,000.00** | **23,765,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,150,000.00** | **23,765,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,150,000.00 | 23,765,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,150,000.00 | 23,765,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-2,150,000.00** | **-23,765,000.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 4,015,294.10 | 58,768,834.33 |
| **9** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 731,371.12 | 4,746,665.22 |
| **10** | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 4,746,665.22 | 63,515,499.55 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **340,824,288.00** | **93,308,650.08** | **54,817,792.09** | **488,950,730.17** |
| Тайлант үеийн үр дүн | 25,198,000.00 | 00.00 | -56,890,161.93 | -31,692,161.93 |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **366,022,288.00** | **115,588,756.87** | **612,763,014.00** | **1,094,374,058.87** |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -124,883,462.72 | -124,883,462.72 |
| **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **366,022,288.00** | **115,588,756.87** | **487,879,551.28** | **969,490,596.15** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
**Улсын төсвийн гүйцэтгэл:**

төгрөгөөр

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **1,675,388,000.00** | **1,621,852,073.11** | **53,535,926.89** | **96.8** |
| **Татварын бус орлого** | **1,675,388,000.00** | **1,621,852,073.11** | **53,535,926.89** | **96.8** |
| Нийтлэг татварын бус орлого | 134,544,500.00 | 121,634,093.80 | 12,910,406.20 | 90.4 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 134,544,500.00 | 121,634,093.80 | 12,910,406.20 | 90.4 |
| Тусламжийн орлого | 1,540,843,500.00 | 1,500,217,979.31 | 40,625,520.69 | 97.4 |
| Хандив тусламж /дотоод/ | 1,540,843,500.00 | 1,500,217,979.31 | 40,625,520.69 | 97.4 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,680,134,700.00 | 1,563,083,238.78 | **117,051,461.22** | **93.0** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,680,134,700.00 | 1,563,083,238.78 | **117,051,461.22** | **93.0** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,560,275,100.00 | 1,458,555,469.78 | **101,719,630.22** | **93.5** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,096,827,700.00 | 1,047,144,584.90 | **49,683,115.10** | **95.5** |
| Үндсэн цалин | 548,472,000.00 | 533,930,767.66 | 14,541,232.34 | 97.4 |
| Нэмэгдэл | 375,277,300.00 | 374,359,190.84 | 918,109.16 | 99.8 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 53,573,600.00 | 34,955,000.00 | 18,618,600.00 | 65.3 |
| Урамшуулал | 119,504,800.00 | 103,899,626.40 | 15,605,173.60 | 86.9 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 150,833,000.00 | 132,025,663.88 | **18,807,336.12** | **87.5** |
| Тэтгэврийн даатгал | 105,978,800.00 | 89,539,763.88 | 16,439,036.12 | 84.5 |
| Тэтгэмжийн даатгал | 11,213,500.00 | 10,424,100.00 | 789,400.00 | 93.0 |
| ҮОМШӨ-ний даатгал | 5,606,800.00 | 5,606,800.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 5,606,800.00 | 5,606,800.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 22,427,100.00 | 20,848,200.00 | 1,578,900.00 | 93.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | 80,053,700.00 | 72,933,974.00 | **7,119,726.00** | **91.1** |
| Бичиг хэрэг | 8,753,100.00 | 8,490,700.00 | 262,400.00 | 97.0 |
| Тээвэр, шатахуун | 45,894,800.00 | 45,889,174.00 | 5,626.00 | 100.0 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,015,700.00 | 2,976,000.00 | 5,626.00 | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,960,500.00 | 4,148,500.00 | 3,039,700.00 | 49.5 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 11,429,600.00 | 11,429,600.00 | 3,812,000.00 | 52.1 |
| **Нормативт зардал** | 128,431,900.00 | 125,518,467.00 | **-** | **100.0** |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 103,604,300.00 | 103,596,531.00 | 2,913,433.00 | 97.7 |
| Хоол, хүнс | 22,863,800.00 | 19,961,936.00 | 7,769.00 | 100.0 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,963,800.00 | 1,960,000.00 | 2,901,864.00 | 87.3 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | 63,686,000.00 | 47,761,000.00 | **3,800.00** | **99.8** |
| Багаж, техник, хэрэгсэл | 27,115,500.00 | 23,782,000.00 | 15,925,000.00 | 75.0 |
| Тавилга | 4,250,600.00 | 0 | 3,333,500.00 | 87.7 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 12,819,900.00 | 11,900,000.00 | 4,250,600.00 | - |
| Урсгал засвар | 19,500,000.00 | 12,079,000.00 | 919,900.00 | 92.8 |
| **Томилолт, зочны зардал** | 9,288,600.00 | 8,129,600.00 | **7,421,000.00** | **61.9** |
| Дотоод албан томилолт | 9,288,600.00 | 8,129,600.00 | 1,159,000.00 | 87.5 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 13,254,200.00 | 7,142,480.00 | **1,159,000.00** | **87.5** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,201,500.00 | 4,824,000.00 | 6,111,720.00 | 53.9 |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,424,400.00 | 1,152,000.00 | 5,377,500.00 | 47.3 |
| Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 289,900.00 | 272,400.00 | 80.9 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 722,300.00 | 621,986.00 | 60,100.00 | 82.8 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 99,000.00 | 99,000.00 | 100,314.00 | 86.1 |
| Газрын төлбөр | 250,000.00 | 75,594.00 | - | 100.0 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 207,000.00 | 80,000.00 | 174,406.00 | 30.2 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17900000 | 17899700 | 127,000.00 | 38.7 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 17,900,000.00 | 17,899,700.00 | **300** | **100.0** |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 119,859,600.00 | 104,527,769.00 | 300 | 100.0 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | 119,859,600.00 | 104,527,769.00 | **15,331,831.00** | **87.2** |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 68,411,600.00 | 53,179,769.00 | 15,331,831.00 | 87.2 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 51,348,000.00 | 51,348,000.00 | 15,231,831.00 | 77.7 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100,000.00 | 0 | - | 100.0 |
| **ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ** | **-4,746,700.00** | **58,768,834.33** | | |
| **АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,746,700.00** | **-58,768,834.33** | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт** | **4,746,700.00** | **-58,768,834.33** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 4,746,665.22 | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 63,515,499.55 | | |

**Орон нутгийн төсвийн гүйцэтгэл:**

төгрөгөөр

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| **НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН** | **44,817,500.00** | **44,817,500.00** | **-** | **100.0** |
| Татварын бус орлого | 44,817,500.00 | 44,817,500.00 | - | 100.0 |
| Тусламжийн орлого | 44,817,500.00 | 44,817,500.00 | - | 100.0 |
| Төсвөөс санхүүжих | 44,817,500.00 | 44,817,500.00 | - | 100.0 |
| **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **44,817,500.00** | **44,817,500.00** | **-** | **100.0** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **44,817,500.00** | **44,817,500.00** | **-** | **100.0** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **44,817,500.00** | **44,817,500.00** | **-** | **100.0** |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **42,754,500.00** | **42,754,500.00** | **-** | **100.0** |
| Гэрэл, цахилгаан | 7,604,500.00 | 8,079,500.00 | -475,000.00 | 106.3 |
| Түлш, халаалт | 34,650,000.00 | 34,650,000.00 | - | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 500,000.00 | 25,000.00 | 475,000.00 | 5.0 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,063,000.00** | **2,063,000.00** | - | 100.0 |
| Урсгал засвар | 2,063,000.00 | 2,063,000.00 | - | 100.0 |
| Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | **-** | **-** | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70,158.5 мянган төгрөгийн 14 алдаа, зөрчил илэрснээс, 53,550.9 мянган төгрөгийн 8 алдааг залруулж, 16,607.6 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгч, нийцлийн аудитаар илэрсэн 2 зөрчилд зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

### 3.1. Залруулсан алдаа

- Жилийн эцсийн санхүүгийн тайланг бэлтгэж ирүүлэхдээ тайлант оны худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийг гаргаж ирүүлээгүй, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн маягтын дагуу тайланг бэлтгэж ирүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7 “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах;” заалттай нийцэхгүй “толилуулга” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад нөхөж гаргасан.
- Аймгийн Эрүүл мэндийн газраас шилжиж ирсэн тэтгэмжийн орлогын бичилтийг 30,319.4 мянган төгрөгөөр дутуу хийснээс мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулга хийсэн.
- Тайлант онд худалдан авсан 1,540.0 мянган төгрөгийн автомашины дугуйг ашиглалтад тавьж олгохдоо картлаагүй, шууд зарлага болгосон нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулга хийсэн.

- Тайлант онд худалдаж авсан 7,588.8 мянган төгрөгийн барилгын засварын материалыг аж ахуйн материалын дансанд орлого авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулга хийсэн.
- Ажиллагсдад хоолны хөнгөлөлт, томилолтын зардлыг давхардуулж 90.0 мянган төгрөг илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалттай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул 2026 оны 1-р сарын цалингаас суутгаж залруулсан.
- Нийгмийн даатгалын шимтгэлийг 162.2 мянган төгрөгөөр илүү шилжүүлж, авлагаар бүртгээгүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалттай нийцэхгүй, "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад тооцоо нийлүүлж, авлагаар тусгуулсан.
- Төсвийн эдийн засгийн ангилал зөрчиж 9,403.7 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул аудитын явцад залруулсан.
- Аймгийн ЗДТГ-аас 2023 онд үнэ төлбөргүй ирснээр бүртгэсэн, биетээр байхгүй, хууль хяналтын байгууллагад хянагдаж буй 3 ш зөөврийн компьютерт элэгдэл байгуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байх тул элэгдлийг зогсоож, анхны өртгөөр нь бүртгэлд тусгаж залруулав.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 16,607.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 22,944.0 мянган төгрөгөөс 6,336.4 мянган төгрөгөөр бага тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

### 3.2. Албан шаардлага

1. Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 31, зарлагын 9 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн нь өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6 дугаар зүйлийн 6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасан заалттай нийцэхгүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байгаа нь "нийцсэн бөгөөд зохистой" батламж мэдэгдлийг хангахгүй байна. Иймд зөрчил таслан зогсоох тухай албан шаардлагыг хүргүүлсэн.
2. Улаан-Уул сумын эрүүл мэндийн төв нь 2025 онд цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой 18,645.9 мянган төгрөгийн эмийг шууд худалдан авсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс

худалдан авна.” заалттай нийцэхгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байх тул зөрчил таслан зогсоох албан шаардлага хүргүүллээ.

**3.2. Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1.Төлбөртэй үйлчилгээний орлоготой холбоотой асуудал**

*Илрүүлэлт*:

Төлбөртэй үйлчилгээний орлого 2,200.0 мянган төгрөгийг Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.6.10 заалтад заасан “Төсвийн байгууллага нь мөнгөн касстаа бэлнээр хүлээн авсан үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогыг шууд захиран зарцуулах эрхгүй бөгөөд ажлын дараагийн өдөрт багтаан төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана;” заалтыг хэрэгжүүлээгүй байгаа нь “үнэлгээ ба батламж” мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*

Төлбөртэй үйлчилгээний орлогыг тухай бүрд нь байгууллагын харилцах дансанд төвлөрүүлэх

**2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт 1*:

Ажил олгогчоос олгох нийгмийн даатгалын шимтгэл, цалингийн бүлэг хооронд 2,350.9 мянган төгрөгийн гүйлгээг эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2.”батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;”заалттай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Илрүүлэлт 2*:

Байгууллагын ажиллагсдыг Уран голомт ХХК-ийн Happy med эмнэлэгт эрүүл мэндийн үзлэгт оруулахдаа хөдөлмөр хамгааллын зардлаас 11,900.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалттай нийцэхгүй “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх

**3. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт* :

Байгууллагын данс бүртгэлээс акталж хассан автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулаагүйгээс шалтгаалан 156.7 мянган төгрөгийн татварыг нөхөн төлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,

баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;”заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Данснаас хассан автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс тухай бүр хасуулах

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн бүрэлдэхүүнээр, батлагдсан маягтаар бэлтгээгүй. | 1 | - | 1 | - | | | 1 | - | | |
| Аймгийн ЭМГ-аас шилжиж ирсэн тэтгэмжийн орлогын бичилтийг дутуу хийснээс мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй тайлагнасан. | 1 | 30,319.4 | | | 1 | 30,319.4 | 1 | 30,319.4 | | |
| Худалдан авсан автомашины дугуйг ашиглалтад тавьж олгохдоо картлаагүй, шууд зарлага болгосон | 1 | 1,540.0 | | | 1 | 1,540.0 | 1 | 1,540.0 | | |
| Худалдаж авсан барилгын засварын материалыг аж ахуйн материалын дансанд орлого авсан | 1 | 7,588.8 | | | 1 | 7,588.8 | 1 | 7,588.8 | | |
| Ажиллагсдад хоолны хөнгөлөлт, томилолтын зардлыг давхардуулж олгосон | 1 | 90.0 | | | 1 | 90.0 | 1 | 90.0 | | |
| Нийгмийн даатгалын шимтгэлийг илүү шилжүүлж, авлагаар бүртгээгүй | 1 | 162.2 | | | 1 | 162.2 | 1 | 162.2 | | |
| Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийснийг систем дээр залруулсан. | 1 | 9,403.7 | | | 1 | 9,403.7 | 1 | 9,403.7 | | |
| Аймгийн ЗДТГ-аас 2023 онд үнэ төлбөргүй ирснээр бүртгэсэн, биетээр байхгүй 3 ш зөөврийн компьютерт элэгдэл байгуулсан | 1 | 4,446.8 | | | 1 | 4,446.8 | 1 | 4,446.8 | | |
| Дүн | **8** | **53,550.9** | **1** | **-** | **7** | **53,550.9** | **7** | **53,550.9** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хөдөлмөр хамгааллын зардлаас ажиллагсдын эрүүл мэндийн үзлэгийн зардал гаргасан | 1 | 11,900.0 | | | | | 1 | 11,900.0 |
| Акталсан тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулаагүйгээс автотээврийн хэрэгслийн татвар, хураамжийг нөхөж төлсөн | 1 | 156.7 | | | | | 1 | 156.7 |
| Шүдний төлбөртэй үйлчилгээний орлогыг тухай бүрт нь дансанд тушаагаагүй. | 1 | 2,200.0 | | | | | 1 | 2,200.0 |
| Эдийн засгийн ангилал зөрчиж гүйлгээ хийсэн. | 1 | 2,350.9 | | | | | 1 | 2,350.9 |
| **Дүн** | **4** | **16,607.6** | | | | | **4** | **16,607.6** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хрэгжүүлээгүй. | 1 | - | | | 1 | - | | |
| Цахим дэлгүүрээс худалдан авах боломжтой эм, эмнэлгийн хэрэгслэлийг шууд худалдан авсан. | **1** | **-** | | | **1** | **-** | | |
| Дүн | **2** | **-** | | | **2** | **-** | | |

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| A | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |